Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2015-12-11/

Ажлын хэсгийн 39 дүгээр хуралдаан 2015 оны 12дугаар сарын 11-ны өдрийн 10.00 цагт Татварын Ерөнхий газрын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхайн яамны СТБГ-ын дарга Н.Энхбаяр, Уул уурхайн хэлтсийн дарга Д.Дамба, Ашигт малтмалын газрын дарга Д.Үүрийнтуяа, АМГ-ын уул уурхайн хэлтсийн дарга С.Баттулга, мэргэжилтэн Г.Оюунтуяа, Сангийн яамны мэргэжилтэн Г.Зулай, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Газрын тосны газрын мэргэжилтэн н.Чулуунбат, Татварын ерөнхий газрын татварын ахлах байцаагч Ч.Батчимэг, байцаагч Д.Энхтуяа,Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Ариун суврага хөдөлгөөний тэргүүн Г.Чагнаадорж, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Монголын Байгал эхийн аврал сан ТББ-ын тэргүүн Н.Наранцэцэг, Нээлттэй нийгэм форумын мэргэжилтэн Д.Эрдэнэчимэг, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, Хариуцлагатай уул уурхай ТББ-ын ТУЗ-ын гишүүн Л.Долгормаа, Алт үйлдвэрлэгчдийн холбооны ажлын албаны дарга Г.Наранзаяа, Оюутолгой ХХК-ны ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, Бороо гоулд ХХК-ны мэргэжилтэн П.Болормаа, Петро Чайна Дачин тамсаг ХХК-ны гүйцэтгэх дэд захирал Ван Лян Дай, Арева Монгол ХХК-ны менежер Энхжаргал, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Хүний эрх хөгжил төвийн ажилтан Н.Байгалмааг орлож Мөнх-орхон, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн Д.Энхболдыг орлож, менежер Б.Энхжин, Транспаренси Интернэшнл Л.Төр-одыг орлож ажилтан Э.Мөнхжаргал нар оролцов.

Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 22 гишүүн оролцож ирц 66 хувьтай байв.

Мөн хуралдаанд Кэй Пи Эм Жи ХХК-ийн партнер Эбэрст Марк, аудитор Ш.Номиндарь,ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хурлыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОҮИТБС-ын Ажлын хэсгийн ахлагч Б.Дэлгэрмаагийн зааврaар Уул уурхайн яамны СТБГ-ын дарга Н.Энхбаяр удирдан явуулав.

Н.Энхбаяр: Монголын ОҮИТБС-ын Ажлын хэсгийн 39 дүгээр хуралдаан эхэлэхэд бэлэн боллоо. Журмын дагуу ажлын хэсгийн хурлын хөтөлбөр, дотоод журмыг уншиж танилцуулъя. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал гишүүдэд байна уу? Байхгүй бол хэлэлцэх асуудлаа батлаад, хурлаа эхлэе.

Гишүүд дэмжсэнээр хуралдаан эхлэв.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2014 оны тайлан

Эберст Марк: Юуны ОҮИТБС-ын 2014 оны хараат бус аудитаар ажилласандаа баяртай байна, өнөөдөр тайлангаа танилцуулж байгаадаа таатай байна. Танилцуулга маань цагтаа багтахгүй байж магадгүй, бид аудитын гол зорилго цаашлаад тулгасан бэрхшээл, зөвлөмжийн талаар ярилцая. Бид ОҮИТБС-ын ажлын албатай тохиролцсоны дагуу 2 чиглэлээр тайлангаа хийхээр

болсон, үүнд нэгдүгээрт улсын хэмжээнд, хоёрдугаарт орон нутгийн хэмжээнд, нэгтгэл хийхдээ нэг бүрчлэн нэгтгэх, түүвэрчлэн нэгтгэх гэсэн аргаар хийсэн байгаа. Биддөрвөн босгыг ашиглан нэгтгэлд хамрагдах компаниудаа сонгосон.Тухайлбал улсын хэмжээний орлого 250 саяас дээш орлоготой байвал нэг бүрчилэн харин 100-250 сая төгрөгний хооронд байвал түүвэрчлэлийн аргаар компаниа сонгоод нэгтгэл тайландаа оруулсан байгаа. Орон нутгийн хэмжээнд 100 сая төгрөгнөөс дээш орлоготой байвал бүлэг нэг гэж үзээд нэг бүрчлэн нэгтгэлд хамруулсан, харин 30-100 сая төгрөгийн хооронд орлоготой компаниудыг бүлэг хоёр гэж үзээд түүвэрчлэх аргаар нэгтгэлд орох компаниудаа сонгосон. Үүний үр дүнд материаллаг нөхцлийг хангасан, нэгтгэлд хамрагдах улсын хэмжээний 183 компани гарсан, улсын хэмжээнд түүвэрлэх материаллаг нөхцлийг хангасан 133 компани гарч ирсэнээс түүвэрлэж, 44 компанийг нэгтгэлд хамруулахаар сонгож, нийтдээ улсын хэмжээний нэгтгэлд 227 компанийг нэгтгэлд хамруулахаар болсон. Орон нутгийн хэмжээнд нэгтгэлд хамрагдах компанийг адилхан аргачлалаар сонгоод нийт 81 компани нэгтгэлд хамрагдсан. Эдгээр компанийн 72 компани нь улсын болон орон нутгийн нэгтгэлд давхардаж орсон байсан учраас давхардсан тоог хасаад 236 компани 2014 оны нэгтгэлд орсон.

Бид эдгээр 236 компанийн нэгтгэлийн үр дүнг танилцуулахаар бэлтгэсэн байна. Анхны зөрүү нь 264 тэрбум төгрөг байсан, Засгийн газрын тайланд 1,9 их наяд төгрөг, компанийн тайланд 1,65 их наяд төгрөг байсан. Засгийн газрын тайлан 1,57 их наяд, компанийн тайлан 1,57 их наяд болж өөрчлөгдөн, зөрүү нь нилээд багасан зөрүү нь 2,4 тэрбум төгрөг болсон байна. Компаниуд нь анхны тайлангаа цахимаар гаргаагүй эсвэл зөрүүгийн тайлбарын хариугаа бидэнд ирүүлээгүйгээс дээрх зөрүү гарсан ба үүнийг хичнээн хөөцөлдөөд ч залруулах боломжгүй байсан. Энэ тоо нь бараг 2,4 тэрбум төгрөг болсон байсан, тэгээд анхны тайлангаа ирүүлээгүй болон залруулгын тайлангаа ирүүлээгүй компанийн дүнг хасвал нийт 577 сая төгрөгний зөрүү гарч байгаа юм. Компани төлбөрөө буруу тайлагнасан, буцаасан төлбөрүүд хасагдаагүй, өөр компанийн өмнөөс хийсэн төлбөрийг тайлагнасан, зарим тохиолдолд олборлохоос бусад үйл ажиллагаа болон олборлохтой хамаагүй үйл ажиллагааг оролцуулсан зэргээс үүдэн зөрүү гарах шалтгаан болсон./Танилцуулгыг хавсаргав/

Б.Энхбаяр: За танилцуулга хийсэн Эберст Маркад баярлалаа, одоо санал, асуултандаа оръё.

Н.Баярсайхан: 2013 оны зөвлөмжийг үзсэн байна. Урьд жилүүдийн тайлангийн зөвлөмжүүдийг авч үзсэн үү? Хоёрдугаарт, тайланг ашиглах аргачлалыг[1] боловсруулж байна уу? Энэ тайланд орж амжих уу? Орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээний маш их мэдээллийг оруулсан байна. Сайн байна. Гэхдээ үйл ажиллагаа явуулахын тулд заавал байгуулдаг ус ашиглах гэрээ, газар ашиглах гэрээ зэрэг бүх мэдээллийг оруулж байснаас чухал гэсэн тухайлбал ашигт малтмалын тухай хуулийн 42.1-ийн дагуу байгуулсан гэрээний мэдээллийг оруулж болохгүй юу?

Эберст Марк: 2013 оны тайлангийн зөвлөмжинд илүү анхаарлаа хандуулсан ба тэрнээс урьд жилүүдийн зөвлөмжүүд хүчин төгөлдөр байсан бол 2013 оны зөвлөмжинд орох байсан байх.

Бид ажлын даалгавар, ажлын гэрээний дагуу тайлангаа бэлтгэсэн ба тайланг уншигчдад дөхөм болох үүднээс тайлангийн эхний хэсэгт нэмж илүү

[1]Зааварчилгаа гэж ойлгоно.

дэлгэрэнгүй агуулгыг оруулж өглөө. Ингэсэнээр тухай уншигч сонирхсон мэдээллээ хялбархан олоод унших боломжтой юм. Бид Эхлэлтийн семинарт ОТАХ-ийн тохиролцсоны дагуу гэрээг ил болгох хүсэлт явуулж бидэнд ирсэн бүх мэдээллийг тайландаа оруулсан байгаа. Хэрэв ОТАХ нийтээрээ энэ мэдээлэл тайланд орох шаардлагагүй гэж үзвэл тайлангаас хасаж болно.

Э.Сумъяа: Хоёр асуулт байна. Тайлантай нилээн сайн танилцлаа. 236 компанийн 92 нь ямар ч зөрүү алга байна, 89 нь Засгийн газар талдаа, 55 нь компани талдаа юм байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэр 4 тэрбум 166 сая төгрөг гэж байна энэ хамгийн их зөрүү банйа. Энэ зөрүү ямар шалтгаанаар үлдсэн юм бэ? Мөн энэ асуултыг Сангийн яам, Татварын ерөнхий газраас асууя. Хөндлөнгийн хараат бус хянагч-нэгтгэгчийг 1 дүгээр сараас эхэлж ажиллуулаачээ гэж зөвлөмж өгчээ. Энэ хэр оновчтой зөвлөмж бэ? 1-р сард аль ч байгууллага санхүүгийн тайландаа аудит хийлгэж амжихгүй, гэтэл бид тайлагна гээд шахчихаар буруу мэдээлэл гаргуулах гээд байна. Биднийг улам будлиулах гээд байгаа юм биш биздээ?

Эберст Марк: Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хувьд анх цахимаар 2014 оны тайланг гаргасан боловч биднээс тайлангийн тодруулга удаа дараа явуулахад татгалзсан хариу өгсөн. Өгөхгүй байгаа шалтгаанаа энэ жил хувьчлалд орж байгаа, урьд хийсэн нягтлан бодогч нь солигдсон гэж тайлбарласан. Бид ТЕГ болон Сангийн яамнаас тодруулга авахыг хичээсэн ч компани талаасаа нарийн тайлбаргүй болохоор төрийн байгууллагууд нарийн тайлбар хийх боломжгүй байсан.

Бид зөвлөмжиндөө Хараат бус хянагч-нэгтгэгчийг компаниуд тайлангаа гаргаж эхлэхээс өмнө тайлангийн бэлтгэл ажилд ялангуяа тайлангийн маягт бэлтгэх явцад хамруулбал дараа нь байгууллагуудаас Хараат бус хянагч-нэгтгэгч олон мэдээлэл хүсэхгүй үйл явц илүү үр дүнтэй хурдан явах боломжтой гэж үзлээ. Мөн тайлангийн бэлтгэл ажлын явц удаан үргэлжилдэг тул эртнээс оролцуулах нь зүйлтэй гэж үзсэн.

Бороо гоулд ХХК П.Болормаа: Энэ жил Кэй Пи Эм Жи мэргэжлийн аудитын байгууллагатай хамтарч ажиллахад бидний хувьд маш амар байлаа. Өмнөх жилүүдэд тухайлбал хөрөнгө оруулалт гэж юуг хэлэх үү гэх мэт тодорхойлолтууд дээр аудитор компани хоёр өөр өөрөөр ойлгож, зөрүүтэй ойлголттой байснаас ажлын уялдаа холбоо алдагдаж, их хүндрэлтэй байсан. Харин энэ жил мэргэжлийн аудитын компанитай хамтарч ажиллахад маш хялбар, шууд ойлголцож байлаа. Зөвлөмжийн тухайд цахим тайлагналын системийн платформ дээр зөвлөмж өгөхдөө нэг зүйлийг их анхаармаар байна. Нягтлан бодогч нар бүтэн жил энэ тайланг бэлтгэж, мэдээллээ цахим системд оруулж байгаа. Гэтэл кибер аюулгүй байдлаас шалтгаалан нууцлалаа алдах, мэдээллээ алдах гэх мэт эрсдэлүүд гарвал яах вэ?

Эберст Марк: Бидний зөвлөмж №1-тэй санал нэг байна. Бид энэ тал дээр илүү нарийн ажиллаасай гэж зөвлөж байна.

Д.Эрдэнэчимэг: Шинэлэг зүйлүүд нилээд ажиглагдлаа. Ялангуяа нэгтгэлийн ажлын цар хүрээг тодорхойлох семинар дээр иргэний нийгмийн байгууллагууд 8

асуудлаар 4 хуудас санал өгсөн. Тэдгээр саналуудын алийг нь хэрэгжүүлж болох, алийг нь ямар шалтгааны улмаас хэрэгжүүлж болохгүй талаар эхлэлтийн тайландаа дэлгэрэнгүй дурьдаж байсан. Бид нарын өгсөн саналуудын ихэнх нь тусгагдсан байна. Ялангуяа нөхөн сэргээлтийн тусгай зөвшөөрөлтэй компаниудын мэдээлэл, төрийн өмчит компани Засгийн газар хоорондын шилжүүлэг түүний аргачлал гэх зэрэг нилээдгүйг нь тусгажээ. Нэг санал, 4 асуулт байна. Тайланг эхлээд Англи хэл дээр боловсруулаад Монгол хэл рүү хөрвүүлсэн юм шиг байна. Англитай нь тулгаад уншихаар ойлголтын зөрүү үүсч байна. Тэгэхээр орчуулгаа сайн нягтлаарай. Тухайлбал, "тайланг ажлын албатай байгуулсан гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн. Тэр утгаараа ОҮИТБС-ын оролцогч талуудаас бусад этгээдүүд агуулгад найдаж үл болно" гэсэн байна. Гэтэл миний ойлголтоор энэ тайланг олон нийтэд ойлгомжтой байдлаар тэдэнд хүргэх гэж гаргаж байгаа. Үүнийг тодруулж өгнө үү. Хоёрдугаарт, хавсралт 23 дээр байгаль орчны тусгай санд төвлөрүүлсэн хөрөнгийн жагсаалт гэсэн хүснэгт байна. Гэтэл энэ хүснэгтийн хойд талд нь хувиуд байна, ямар нэгэн тайлбар байхгүй. Тиймээс үүнийгээ цаашид олон нийтэд ойлгомжтой байдлаар тайлбар оруулж өгөөрэй гэж хэлэх байна. Зарим нэг товчилсон үгийн тайлбар байхгүй байна. Бас нэг газар зөвхөн Хэнтий аймгийн мэдээллийг ялгаж аваад харуулсан байсан, энэ ямар учиртай юм бэ? Бусад аймгуудын мэдээлэл яагаад ороогүй вэ?

Эберст Марк: Монгол орчуулга дахин хянагдаж байгаа. Эцсийн тайланд хянагдсан хувилбараар орно. Тайлан дахь хязгаарлалтын талаарх мэдэгдлийг нэмж зассан байгаа. Хавсралт 23 дахь хувийн хэмжээг дэлгэрүүлэн бичье. Товчилсон үгийн тайлбарыг дахин хянасан байгаа. Орон нутгийн шилжүүлгийн талаар бид бүх аймгуудаас асууснаас зөвхөн Баян-Өлгий болон Хэнтий аймгууд мэдээлсэн байснийг тайландаа оруулсан. Бид энэ талаар илүү тодорхой болгож тайландаа оруулсан.

Б.Баярмаа: Нэгтгэлийн ажлын амжилттай хийсэн танай компанид талархал илэрхийлье. Лицензийг ил тод болгохыг хийсэн байгаад талархаж байна, үүнтэй холбоотой асуулт байна. Лицензийг сонгон шалгаруулах үйл явц гэсэн хэсэг дээр нэг кэйс сонгож аваад оноотой нь танилцжээ. Тэгээд оноог нь шалгах үндэслэлгүй байсан гэж бичсэн байсан. Яагаад үүнийг шалгах боломжгүй байв гэдгийг тайлбар оруулж болох уу? Лицензийн мэдээлэл харьцангуй ил байсан, гэтэл энэ тайлан дээр лицензийн хугацааг үзэх боломжгүй, онцгой эрх авч байж үзэх боломжтой гэж бичсэн байна. Хэзээ, ямар хууль тогтоомжийг үндэслээд хэн ийм шийдвэр гаргачихваа? Нээлттэй байдлаасаа ухарч байна. Үүний тайлбарыг тайландаа тусгаарай. Гуравдугаарт, бенефициар өмчлөгчийн мэдээллийг ОҮИТБС-ын стандартаар заавал ил болгох шаардлагагүй ч үүнийг ил болгохоор бид зорьж байгаа. ТАН эвслийн зүгээс бид яг энэ асуудлаар судалгаа хийсэн. Энэ мэдээллүүдийг та бүгд энэ тайландаа оруулж болох уу? 85 хуудас тайлан бий.

Д.Үүрийнтуяа: Уул уурхайн яам болон манай Ашигт малтмалын газар өнгөрсөн онд батлагдсан Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогыг баримтлан ажиллаж байгаа. Бид ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгохдоо аль болох нээлттэй ил тод, хариуцлагатай байх зарчмыг байнга хэрэгжүүлж ажиллаж байгаа. Ялангуяа манай кадастрийн үйл ажиллагаа бүрэн нээлттэй болсон, бүх үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлсэн. Манай вебсайт руу ороход бүх мэдээлэл нээлттэй байгаа. Олгосон огноо, дуусгавар болгох огноо нь хаалттай байна гэж байна, энэ нь тайлангийн хавсралтад харуулсан байна, энэ

бол нээлттэй харин эрх авна гэдэг нь тайлан төлөвлөгөө шивэх үедээ цахим гарын үсэгтэй адил тусгай эрх авч, түүгээрээ нэвтэрч орох боломжтой. Энэ талаарх хүсэлтийг манайд албан бичгээр илрүүлсэн, түүнээс гадна ОҮИТБС-ын тайлангийн програмтай манай программтай нэгтгэх хүсэлт ирүүлсэн. Үүнийг нэгтгэх биш, харин мэдээлэл нь нээлттэй ил тод байгаа, олж авч чадахгүй байгаа мэдээллийг олж авахад туслах боломжтой.

Н.Баярсайхан: Сонгон шалгаруулалтын үйл явцын талаар асуумаар байна.

Д.Үүрийнтуяа: 2014 онд Сонгон шалгаруулалтын журам батлагдаад, өнгөрсөн хугацаанд дөрвөн удаа шалгаруулалт явуулаад, тав дахийг зарлаад явж байна. Ер нь сонгон шалгаруулалттай холбоотой маргаанууд бараг байхгүй болж цэгцэрсэн. Сонгон шалгаруулалтыг 2 үе шатаар явуулж байна. Үүнд, эхлээд техникийн саналыг үнэлээд дуусаны дараа аж ахуйн нэгжүүдийг байлцуулан битүүмжилсэн санхүүгийн саналыг нээж, программд оруулах замаар шалгаруулалтыг явуулж байна. Аж ахуйн нэгжүүд өөрсдөө оролцож байгаа учраас гомдол, маргаан гарах нь багассан, хэрвээ гомдол гаргавал ажлын 5 өдөрт багтаан шалгаж хариуг 10 өдрийн дотор мэдэгдэж байгаа.

Б.Баярмаа: Сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдхүүнд ИНБ-ууд ороогүй байсан түүгээрээ явж байна уу?

Д.Үүрийнтуяа: Сонгон шалгаруулалтын журам Хууль зүйн яамаар батлагдсан, шалгаруулах комиссын бүрэлдэхүүнд нь Геологийн холбоо, Уул уурхайн ассоциаци зэрэг мэргэжлийн холбоод орж байгаа. Яагаад гэвэл тенхикийн саналыг үнэлэхэд мэргэжлийн хүмүүс шаардлагатай байдаг.

Б.Баярмаа: Сонгон шалгаруулах журам нь өөрөө ил тод байх хэрэгтэй юм, ил тод байлгах стандартын шаардлага бий.

Д.Үүрийнтуяа: Бид сонгон шалгаруулалтын үйл явцыг нээлттэй явуулж байгаа, сонгон шалгаруулалтад оролцож байгаа аж ахуйн нэгжүүд бие биеэ хянаж байгаа нь өөрөө том хяналт юм. Мөн өргөдлөөр лиценз олгож байгаа аргыг хүмүүс шүүмжилж байсан. Бид өргөдөл гаргасан хүмүүсийг дуудаад программаар явагдаж байгаа процессыг харуулаад өглөөнөөс орой болтол суулгахад, тэд учраа ойлгоод дараагийн удаа ирэхээ больдог. Зарим тохиолдолд ажилд оролцохоор нэрээ өгөөд дараа нь ирэхээ больдог. Энэ нь бидний ажлыг удаашруулах, саад болох зэрэг асуудал гардаг гэдгийг хүмүүс маань ойлгоорой.

Б.Баярмаа: Лицензийг олгох үйл явц нь стандартын гол шаардлага, үүнийг хэрэгжүүлэхэд ИНБ хяналт тавих ёстой.

Н.Энхбаяр: Уучлаарай хурлын дэгийн дагуу нэгдүгээр асуудалтай холбоотой асуулт байвал тавьж болно.

Д.Үүрийнтуяа: Энэ бол өөрсдөө хөрөнгө мөнгөө тавиад өрсөлдөөнд орж байгаа аж ахуйн нэгжийн асуудал юм. Нэг талдаа иргэний нийгмийн асуудал биш, харин лицензээ аваад ажлаа эхлэхээр нь хууль дүрмийн дагуу ажиллаж байнаа гэдэгт хяналтаа тавих нь бидний ажил юм. Түүнээс 10 аж ахуйн нэгж өрсөлдөөнд орж байгаа байдал, шударга болж байна уу гэдэгт оролцох нь чухал биш, харин тусгай зөвшөөрлөө аваад ажилласан хойно нь бид шаардлагаа тавих ёстой.

Эберст Марк: Лицензийн сонгон шалгаруулалтад өгсөн оноог цаг хугацааны хангалтгүй байдлаас үүдэн шалгах боломжгүй байсан. Тайланд бичигдсэнээр буруу ойлгогдохоор байсан тул тайлангаас хассан болно. Энэ тал дээр АМГ хангалттай хариулсан гэж үзэж байна. Эхлэлтийн семинарын үеэр ОТАХ-с энэ тал дээр санал ирүүлээгүй, бид энэ судалгааны талаар энэ хурлын үед л мэдэж байна. Цаг хугацааны шахуу байдлаас бид энэ судалгааг уншиж оруулах боломж хомс байгааг хүлээн авна уу. Хэрвээ ОТАХ энэ тайлангийн талаар оруулах шаардлагатай гэж үзвэл бид тайландаа ийм тайлан байдгийг дурдаж болно.

Ч.Батчимэг: Засгийн газраас тайлагнасан мэдээлэлд олборлох үйлдвэрлэлтэй холбоогүй орлого урсгал орсон байсан гэжээ. Тэгвэл та бүгд компанийн өгсөн мэдээлэл нь олборлох үйлдвэрлийн орлого мөн юм гэж яаж салгаж тогтоосон бэ? Салгасан орлогоороо зөрүүний баталгаажуулалтаа хийсэн юм уу? Дараа нь энэ асуулттай холбоотой нэг санал хэлье. Хэрэв ийм процесс явагдсан бол тухайн аж ахуйн нэгжийн тайланд нэмэлт зүүлт хийгээд тайлбарыг оруулах хэрэгтэй. Түүнчлэн хавсралтад нилээд мэдээлэл оржээ. Эх сурвалжууд нь Ашигт малтмалын газар, Гаалийн ерөнхий газар гэх мэт. Энэ мэдээллүүдээ компанийн өгсөн мэдээлэлтэй тулгалт хийсэн үү? Жишээлбэл, хувийн хөрөнгөөр хийсэн хайгуулын хэмжээ гэсэн мэдээллийг аж ахуйн нэгжүүдийн мэдээлэлтэй тулгасан уу?

Марк Эберст: Бид нэгтгэлд хамрагдсан материаллаг орлогын урсгалуудыг ОҮ-с бусад орлогын урсгалаас ялгаж шалгахдаа компаниас төлөөлөл авснаас гадна АМГ, ГТГ гэх мэт байгууллагын олборлолт, борлуулалтын мэдээлэлтэй давхар тулгасан. Бидний ажлын цар хүрээнд ОТАХ-тэй тохиролцсон материаллаг гэж үзсэн орлогын урсгалыг нэгтгэх ажил орсон. Харин үндсэн мэдээллийн хувьд (нөхцөл байдлын мэдээлэл, тайлангийн 5 хэсэг) бид компаниуд болон ЗГ-ын байгууллагуудаас мэдээллүүдийг цуглуулж илт мэдэгдэхээр гол алдаанууд болон зөрүүнүүд байгаа эсэхийг үзсэн.

Д.Эрдэнэчимэг: ОҮИТБС-ын тайланд орж байгаа гэрээний мэдээллүүд хангалтгүй байна гэж иргэний нийгмийн байгууллагуудаас санал хэлж байсан. Тухайлбал гэрээ байгуулахдаа орон нутгийн иргэдийг оролцуулсан уу? оролцуулсан бол ямар хүрээнд оролцуулсан? Орон нутгийн захиргаатай нөхөн сэргээлт хийх эрх бүхий компаниуд тэр нэрээр хууль бусаар ашигт малтмал олборлож байгаа. Энэ гэрээний мэдээллүүдийг энд багтаая гэсэн санал хэлж байсан. Тухайн үед Кэй Пи Эм Жи компаниудаас нэмэлт мэдээллийн маягтаар энэ мэдээллийг цуглуулна гэж байсан. Гэтэл энэ тайланд гэрээний талаарх мэдээлэл өмнөх жилээс ялгарсан, шинэ зүйл хийсэн харагдахгүй байна. Үүн дээр тайлбар өгнө үү? Ямар нэгэн ажил хийсэн үү?

Ш.Номиндарь: Бид Эхлэлтийн семинарт ОТАХ-ийн тохиролцсоны дагуу гэрээг ил болгох хүсэлт явуулсан. Ялангуяа орон нутагтай байгаль орчин нөхөн сэргээх гэрээ хийсэн компаниудын мэдээллийн бүх аймгуудаас мөн БОНХАЖЯ-с хүсэхэд зөвхөн БОНХАЖЯ хариу өгч бусад бүх аймгууд хариу энэ тал дээр өгөөгүй. Илүү дэлгэрэнгүйг тайлангийн 5.5.6 хэсгээс харна уу. Хэрэгтэй гэж үзвэл

төрийн байгууллагууд болон компаниудруу явуулсан нэмэлт маягтуудыг явуулж болно. Бид өмнөх жилийнхтэй харьцуулахад Эхлэлтийн семинар дээр зөвшилцсөн мөн стандартаар шаардсан бүхий л үндсэн мэдээллийг агуулсан маш өргөн цар хүрээтэй маягтуудыг явуулсан байгаа. Үүнээсээ болоод ч зарим компаниас хэтэрхий их мэдээлэл хүссэн гэсэн шүүмжлэлийг авсан.

Х.Лхамаа: Өнөөдөр тайлангаа батлаад явуулах уу, бид Оюутолгой дээр 11 саналыг хүргүүлсэн байгаа үүнийг оруулж болох уу?

Ш.Номиндарь: Тийм. Бид хэрхэн тусгаж байгаа талаар имэйлээр хариу мэдэгдэх болно.

Н.Баярсайхан: Хоёр санал хэлье. Ажлын хэсгээс одоо энэ тайланд 42.1-ийн дагуу байгуулсан гэрээний мэдээллийг оруулах, бусад гэрээний мэдээллийг хасах, гэхдээ цаад баазад нь үлдэхээр ийм шийдвэр гаргаж өгөх хэрэгтэй. Хоёрдугаарт 12 сарын 21-23-нд сургалт зохион байгуулна гэсэн байна. Энэ сургалтаа зохион байгуулахдаа Кэй Пи Эм Жи тайланг хэрхэн ашиглах вэ гэсэн аргачлалыг зааж, тайландаа оруулах гэсэн саналтай байна. 2016 оны 1 сарын 1-нээс АМНАТ-ын 30% нь орон нутагт хуваарилагдана. Энэ хэрхэн сум, орон нутагт хуваарилах төсөөллийг энэ тайланд оруулж өгөх хэрэгтэй.

Марк Эберст: Бид Эхлэлтийн семинарт ОТАХ-ийн тохиролцсоны дагуу гэрээг ил болгох хүсэлт явуулж бидэнд ирсэн бүх мэдээллийг тайландаа оруулсан байгаа. Хэрэв ОТАХ нийтээрээ энэ мэдээлэл тайланд орох шаардлагагүй гэж үзвэл тайлангаас хасаж болно. Бид ажлын даалгавар, ажлын гэрээний дагуу тайлангаа бэлтгэсэн ба тайланг уншигчдад дөхөм болох үүднээс тайлангийн эхний хэсэгт нэмж илүү дэлгэрэнгүй агуулгыг оруулж өглөө. Ингэснээр тухайн уншигч сонирхсон мэдээллээ хялбархан олоод унших боломжтой юм. Мөн бид 21-23 хооронд болох сургалтад энэ тал дээр бид сонирхсон асуултад хариулах боломжтой. Бид тайландаа 2016 оны 1 сарын 1-с хэрэгжиж эхлэх орон нутгийн хуваарилалтын талаарх хуулийн өөрчлөлтийн талаар (Хэсэг 5.3.3) дурдсан байгаа. Энэ хуваарилалтын төсөөллийг бид хийх нь тохиролцсон горимын олон улсын стандартаас гажиж ажлын цар хүрээнээс гадна байх юм. Хэрэв ОТАХ-т энэ тал дээр төсөөлөл байгаа бол бид тайландаа оруулж болно.

Х.Энхжаргал /Арева Монгол ХХК/: Тайланг ашиглах зааварчилгаа нь энэ тайлангийн гарчиг дээр байгаа юм биш үү? Тэдийн тэдэд ийм мэдээлэл бий гэсэн. Аргачлал гэж юуг хэлээд байна вэ? Ойлголтын зөрүү яваад байна.

Н.Баярсайхан: Шийдвэрийн төсөл дээр санал хэлье. УИХ-д танилцуулах ажлын хэсгийг эндээс байгуулах хэрэгтэй. Үүнийг шийдвэрийн төсөлдөө оруулах хэрэгтэй. Үлдэгдэл төлбөрийг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар батлахаас өмнө шилжүүлэх юм уу?

Шийдвэрлэсэн нь:

1. Тайлангийн төслийг дэмжиж, Үндэсний зөвлөлд танилцуулж, батлуулах ОҮИТБС-ын батлагдсан үндэсний нэгтгэл тайланг УИХ-ын Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хуралд танилцуулах ажлын хэсэг байгуулахаар тохиролцов.
2. Гэрээт ажлын төлбөрийн үлдэгдлийг төлөхийг Ажлын албанд зөвшөөрөв.
3. Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг тусган тайлангийн эцсийн хувилбарыг боловсруулахыг Кей Пи Эм Жи- консорцумд зөвлөмж болгов.
4. 12-р сарын 21-23- ны тайлангийн талаар сургалт зохион байгуулахаар тогтов.

II. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2015 оны үйл ажиллагааны урьдчилсан тайлангийн тухай

Ш.Цолмон: ОҮИТБС-ын 2015 оны үйл ажиллагааны тайланг урьчилан тараасан байгаа. Бид 50 ажил хийхээр төлөвлөснөөс 47 ажлыг хийж гүйцэтгэсэн, Үндэсний зөвлөлийн хурал нэг удаа, Ажлын хэсгийн хурал 2 удаа хуралдаж, нийт 8 дэд хэсэг хороо ажилласан байсан.

ОҮИТБС-ын шинэ стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд, одоогийн хууль эрх зүй орчин, ил байгаа мэдээллүүд, олон улсын зөвлөмжүүдийн дагуу салбарын үндсэн мэдээллийг цуглуулах, боловсруулах ажлуудыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулж, нэгдсэн сан бий болгож, цахим хуудсад байршуулсан, ОУ-ын НБДнГ-ын, ГОУХАН-тэй хамтран шинэ стандартын дагуу баталгаажуулалтад бэлтгэх болон өөрийн үнэлгээний ажлыг зохион байгуулж, Ерөнхий сайдаар нэмэлт ажлын төлөвлөгөө гарган батлуулж, ажилласан бөгөөд туршилтын баталгаажуулалтыг зохион байгуулсан байна. Монгол Улсын ОҮИТБС-ын 2013 оны нэгдсэн тайланг суртчилах ажлын хүрээнд, 2013 оны нэгдсэн тайлангийн дагуу 5 дэд хэсэг гарган ажиллуулж, эхний үр дүнг Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт танилцуулсны дагуу, гэрээнүүд цуглуулах ажлыг зохион байгуулж, гэрээний ил тод байдлын цахим хуудас боловсруулж байна./Танилцуулгыг хавсаргав/

Н.Баярсайхан: Хийсэн ажлын жагсаалтыг танилцууллаа. Түрүү жил бас санал хэлж байсан. Үр дүнгээ тооцож хэлж байгаачээ гэж. 4 бүсэд семинар зохион байгуулсан. Үүнийг зохион байгуулснаар ямар үр нөлөө бий болж байна вэ? Тухайлбал хэдэн аймаг дэд зөвлөлөө шинэчлэн байгуулсан бэ? Орхон, Дархан-уул аймагт дэд зөвлөл байгуулагдсан уу? гэх зэргийг хэлж өгмөөр байна. Хоёрдугаарт, ажлын албаны төсвийг тайлантай хамт танилцуулаачээ гэж. Дэлхийн банк удаан биднийг санхүүжүүлэхгүй. Энэ хугацаанд нилээн сайн ажлуудыг хийж авах хэрэгтэй, энэ хугацаанд иймэрхүү урсгал ажлуудыг хийгээд яваад байвал дараа нь улсын төсвөөр санхүүжих үед дорвитой ажил хийхэд хэцүү болно.

Ш.Цолмон: Бид төсвийн санхүүжилт, болон зарцуулалтыг тараасан байгаа. Улсын төсвөөс 169,8 сая төгрөгнөөс 50,9 сая төгрөг зарцуулсан бөгөөд үлдэгдэл мөнгийг ондоо багтаан гаргахаар Сангийн яаманд хүсэлт хүргүүлээд байгаа. Дэлхийн банкны санхүүжилтээс сургалт суртчилгааны ажилд 184 сая төгрөг төлөвлөснөөс 78 сая төгрөгний ажил хийхээр хүлээгдэж байна. Үйл ажиллагааны зардалд 220,2 сая төгрөгнөөс 185,4 сая төгрөгийг зарцуулсан. Аливаа хийсэн ажлын үр дүнг тухайн өдөрлөг, семинарын дараа тайлан гаргаж, оролцсон

хүмүүсээс санал авч, ажиллаж байгаа. Орхон аймаг ОҮИТБС-ын Дэд зөвлөлийн байгуулсан байгаа, одоо Дархан аймагт байгуулагдаагүй байна. Бид ямар ч байсан хийсэн, зохион байгуулсан ажлуудыг танилцуулж байна. Дараа нь үнэлэлт дүгнэлтээ өгөх байх.

Д.Эрдэнэчимэг: Ажлын албанд 2015 оны тайланг хийж, танилцуулсанд баярлалаа. Нэгэнт жилд хэдэн удаа хуралддаг билээ дээ, асуух асуултын үеэр цагаар хязгаарламааргүй байна. Хэлэлцэх асуудлаасаа халиад байгаа бол хязгаарлаж болно. Ажлын албанд тайлан бэлтгэж танилцуулсанд баярлалаа. 2015 оны хувьд 9 зорилтын хүрээнд 50 ажил төлөвлөөд, явц болон хийгдсэн ажлуудын тайлбарыг хийсэн байгаа ч хийгдээгүй олон ажлууд байна. Энэ бол ажлын албаны тайлан биш, Монгол Улсын ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийнхний ч хийсэн ажлын тайлан. Тиймээс төлөвлөсөн ажлуудаас хийгдээгүй бол яагаад хийгдээгүй, юу нь болохгүй байсан талаар дүгнэлтийг энэ тайландаа оруулах хэрэгтэй. Тухайлбал, 33 дээр орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан сургалт хийгээгүй гэж байна, үүн дээр тайлбар оруулах. Үр дүнгээ ч гэсэн мөн адил, өөрийн үнэлгээ хийсэн гэсэн байна. Гэтэл 6 сарын 3-ны өдөр ерөөсөө 10 хүрэхгүй хүн ирээд, 7-8 хуудас асуултанд 4 цагийн хугацаанд маш яаруу хийсэн. Дотоод үр нөлөөгөө бид бүрэн үнэлэж чадаагүй. Тэгэхээр ажлын тайланг сайжруулах хэрэгтэй. Нөгөө талаар зарим ажлуудыг танилцуулахдаа тэр байгууллагатай хамтран гээд дурьддаг юм байна. Гэтэл Нээлттэй нийгэм форум Үндэсний форумыг зохион байгуулахад 24 сая төгрөгийн санхүүжилт үзүүлсэн. Эдгээр ажлуудыг зохион байгуулахад хамтарч ажилласан талуудаа дурьдвал их сайн байна.

Ш.Цолмон: За ойлголоо.

Н.Баярсайхан: Дэлхийн банктай харьцахад ямар зарчим байдаг юм? Хэд хэдэн удаа Үндэсний чуулганы үеэр ч, Ажлын хэсгийн хурлын үеэр ч зарим ажлуудыг төрийн бус байгууллагуудаар гэрээлж хийлгүүлэх гэсэн саналыг хэлж байсан. Ингэж хийлгэхэд Дэлхийн банкны зүгээс ямар нэгэн бэрхшээл бий юу?

Ш.Цолмон: Байхгүй. Сонгон шалгаруулалт л явуулах ёстой байгаа. 2016 оны төлөвлөгөөнд оруулсан байгаа.

Н.Энхбаяр: За асуулт, санал дуусан бол шийдвэрээ гаргаад дараагийн асуудалдаа оръё.

Шийдвэрлэсэн нь:

1. Ажлын төлөвлөгөөний биелэлтийг Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг тусган эцэслэн гаргаж, Үндэсний зөвлөлд танилцуулахыг Ажлын албанд зөвшөөрөв.

III. Хэлэлцсэн нь: Монгол Улсын ОҮИТБС-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, урьдчилсан баталгаажуулалтын дүнгийн тухай

Ш.Цолмон: Та бүхэнд 2016 оны ажлын төлөвлөгөөний төслийн урьчилан танилцуулсан байгаа. 2015 оны тайлан дээр үндэслэн ОҮИТБС-ын ОУ-ын НБДнГ-аас өгсөн санал, шүүмжлэлийн дагуу 2016 оны төлөвлөгөөний төслийг арай шинэлэг маягаар боловсруулсан байгаа. Үүнд, зорилт, бэрхшээл, үр дүн,

хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хугацаа,хамтран ажиллах байгууллага, зардлын төсөв, эх үүсвэр, биелэлт зэргийг багтаан нилээд дэлгэрэнгүй, нарийвчилсан байдлаар харуулсан. 2016 онд дөрвөн зорилтын хүрээнд 46 ажлыг хийхээр төлөвлөж, бэрхшээл хүрэх үр дүнг тусган харуулсан. Төлөвлөгөөний төслийн тараасан учраас цаг хэмнэх үүднээс товч танилцуулъя.

Баталгаажуулалтын урьдчилсан дүнгийн хувьд хэд хэдэн ажлыг шаардлага хангаагүй гэж үзсэн байна. Тухайлбал, тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл, гэрээний ил тод байдал, төрийн өмчийн оролцоо зэрэг шаардлага хангаагүй гэхдээ ахиц гарсан гэсэн дүгнэлт өгсөн байна. /танилцуулгыг хавсаргав/

Баталгаажуулалтын урьдчилсан дүгнэлтэд орсон ажлуудаас аль ажлыг 2016 оны төлөвлөгөөнд оруулах вэ гэдэгт ажлын хэсгийн гишүүд саналаа өгвөл сайн байна.

Н.Энхбаяр: За асуух асуулт, саналтай хүн байна уу? За энэ хооронд өөрийн саналаа хэлж байя. Үр дүн 3 дээр цахим тайлагналын системийг 2 байгууллагатай холбох юм байна. Ашигт малтмалын газар дээр ашиглагддаг өгөгдлийн сан нь 4 тусдаа зүйл байгаа. Тус тусдаа тухайн үедээ салангид байдлаар боловсруулагдаад өнөөдөр ашиглахад хоорондын мэдээллийн уялдаа холбоо бас янз бүр байна. Эдгээрийг хооронд нь нэгтгэх асуудлаар мэдээлэл технологийн талаас нь иж бүрэн зөвлөгөө авсан байгаа. Ирэх жил үүнийг гүйцэтгэх шат руу орно. Гүйцэтгэхдээ үндэсний дата төв дээр байршуулахаар төлөвлөж байна. Үүнтэй холбоотойгоор ТЕГ, ГЕГ өөрсдийн мэдээллээ байршуулсан байгаа, хэрэв АМГ мэдээлээ тэнд нэгтгэвэл энэ 3 байгууллагын мэдээлэл хоорондоо уялдах боломжтой болох юм. Тэгэхээр ОҮИТБС-ын цахим тайлагналын системийг ч гэсэн энэ ажлын төлөвлөгөөтэй уялдуулах нь зүйтэй. Урьдчилсан баталгаажуулалтын дүн дээр АМГ-аас үйлдвэрлэл, борлуулалтын дүнг 7 хоног бүр гаргадаг байх гээд зөвлөсөн байна. Хууль эрх зүйн орчны хүрээнд 7 хоног бүр аж ахуйн нэгжээс мэдээлэл авахад хүндрэлтэй байдаг. Хуулийн дагуу ГЕГ л 7 хоног бүр мэдээлэл авах боломжтой. Тиймээс хуулийн хүрээнд хүндрэлтэй асуудлаар олон улсын баталгаажуулалтын тайланд зөвлөмж өгөх нь хэр оновчтой вэ , үүнийг бодолцох ёстой.

Г.Ганбат: 2016 оны төлөвлөгөөнд оруулж болно, хамгийн гол нь нөгөө 2 байгууллага маань зөвшөөрөл өгөх шаардлагатай байгаа. Татварын ерөнхий газартай гэрээ хийсэн, АМГазар одоогоор зөвшөөрөөгүй байна.

Н.Энхбаяр: Мэдээллээ шуурхай байдлаар авъя гэвэл ГЕГ-тай холбогдох ёстой. ТЕГ-ын мэдээ бол сарын хоцрогдолтой, үндсэндээ улиралаар хоцорч явдаг.

Г.Ганбат: Төлөвлөгөөндөө ГЕГ-тай холбогдох гэж оруулж болно. Ямар мэдээлээр холбогдохоо тодруулах ёстой.

Н.Энхбаяр: ГЕГ, ТЕГ, АМГ, ГТГ холбогдох гэж ярихаас илүүтэй ерөнхийдөө төрийн албаны мэдээлэл солилцох боломжтой байдлаар асуудлыг ярьж энэ хүрээнд ажил хийгдэж байгаа.

Г.Ганбат: Бүх л төрийн байгууллагатай холбогдох хүсэлтэй байгаа боловч цахим засаглалын ажлын дэд бүтэц нь бүрэн тавигдаж дуусаагүй байгаа учраас хүндрэлтэй болоод байгаа юм.

Д.Цэрэнжав: Тэгэхээр 2016 оны ажлын төлөвлөгөөг харлаа. Жаахан цэгцэлмээр зүйлүүд байна. Мэдээж үүнийг хийхийн тулд бодсон байна, маш их ажил төлөвлөсөн байна, үндэслэл бэрхшээлийг нь гаргаж ирсэн байна. ОҮИТБС гэхээр компани тайлан гаргадаг, засаг тайлан гаргадаг, иргэний нийгэм гэхээр оролцдог ийм юм яваад байна. 2016 оноос бид нар ер нь нэг ажлыг томъёолоод амлаж авъя гэсэн санаа төрж байна. Ноднингоос хойш бид орон нутгийн дэд зөвлөлийг чадавхжуулъя гэж яриад байгаа. Чадахжуулах гээд орхихоор хотоос очоод хэдэн хүн чадавхжуулаад явахаар тэгээд ажил нь зогсчоод байгаа. Тэгэхээр өөр арга зам хэрэгтэй. Тэр нь орон нутагт ОҮИТБС-ын зорилготой болгоё. Тэгэхгүй бол бүтэн жил энэ том тайланг хүлээдэг болчоод байна. Сумын ОҮИТБС гэж нэрлээд, зорилготой болгоод, нэг дээвэр дор бүх ажлуудыг нь оруулаад чиглүүлэх хэрэгтэй. Тухайлбал сум заавал тайлан гаргаад хүндрээд байх шаардлагагүй. Магадгүй жилд 2-3 удаа гурван талын уулзалт хийж болно, гэхдээ үүнийг баярын уулзалт болгож болохгүй, тодорхой загвартай, стандартад оруулах хэрэгтэй. Тэгэх юм бол магадгүй улс орон даяар нэг өдөр энэ уулзалт болж болно. Энэ ажил бол үндсэн санаачилгын ажилтай харшилдахгүй юм. Суманд цөөхөн хэдэн хамгийн чухал гэсэн асуудлуудыг сонгоод авъя. Жишээлбэл 2016 оны 1 сарын 1-нээс АМНАТ-ын 30%-ийг орон нутагт хуваарилах гэж байна. Энэ үед орон нутагт маш идэвхтэй байхгүй бол хяналтаа сайн хийхгүй бол болохгүй үйл явдал юм. За хайгуулын лиценз олгох асуудал байна, энэ бол одоо их сонин яваад байдаг. Ашиглалтын лиценз олгох асуудал байна, гэрээ гээд хандив тусламжийн асуудал байна. Ийм хэдэн асуудлуудыг сонгож аваад орон нутагт үйл явц өрнөж байдаг, гэхдээ эндээс гаргаж өгсөн загварын дагуу явагдаж байх ийм баймаар байна. Тэгэхгүй бол сая Ноён уулын асуудал яав. Орон нутгийн энэ санаачилга явагдсанаар ОҮИТБС-ын хөрс нь болж өгөх ийм үр дүнтэй юмуу гэж харж байна. Тэгээд ТАН эвсэл Дэлхийн банкны зөвлөх үйлчилгээ гэсэн ажлын хүрээнд энэ ажлуудаа оруулаад, загвар гаргаад ингээд ажиллая гэсэн саналтай байна. Төгсгөлд нь хэлэхэд 2016 он бол сонгуулийн жил, нөхцөл байдал өөр болно, тэгэхээр Засаг даргад найдаж байхаар иргэний нийгэм нь илүү давамгайлсан байдлаар ажиллавал тогтвортой юмуу гэж харж байна. Ерөнхийдөө 2016 оны төлөвлөгөө бол дажгүй, гэхдээ иргэний нийгмийн хийж чадах ажлыг багцлаад өгвөл бид амлаж аваад хийхэд бэлэн.

Н.Баярсайхан: Үндэсний зөвлөгөөнөөс гарсан саналуудыг тусгасан байна гэхдээ.. зарим нэг зүйл орхигдсон байна. Баталгаажуулалтын тайлангаас тодорхой ажлуудыг хийхийг зөвлөмж болгосон байна. Иргэний нийгэм ч тодорхой саналуудыг хэлж байсангэх мэтчилэн 2016 оны төлөвлөгөө боловсруулах, 2020 оны стратеги боловсруулах нилээд саналууд гарсан байгаа. Үүнийг нэгтгэж бичих ажил байгаад байна. Ажлын албанаас 2016 оны төлөвлөгөөг арай өөрөөр, форматыг өөрчлөөд хичээл зүтгэл гаргасныг үнэлж байна. Гэхдээ бид үр дүн гаргасан бодитой ажил хиймээр байна. Тухайлбал, гэрээний нэгдсэн сан үүсгэх, бенефициар өмчлөгчийг ил тод болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, 7-р шаардлагын дагуу өөрсдийгөө үнэлэх гэх мэт арай шинэ хандлагаар төлөвлөгөө боловсруулъя. Тэгэхээр миний санал бол Үндэсний зөвлөлийн хурлаас өмнө үүн дээр ажиллах ажлын хэсгийг байгуулах хэрэгтэй гэж бодож байна. 4 дэх удаагаа 2016 оныг дэд зөвлөлийг чадавхжуулах жил болгоё гэж танилцуулга хийж ирсэн. 2016 онд төлөвлөсөн 45 ажлын 11 нь дэд зөвлөлд чиглэсэн үйл ажиллагаанууд байна. Иймд дэд зөвлөлд чиглэсэн ажлыг Улаанбаатар хотоос очиж хэрэгжүүлэхгүй, харин тэднийг чадавхжуулах хэрэгтэй. Энэ намар Дорноговь аймгийн Айраг суманд олон талт хэлэлцүүлэг уулзалт хийсэн. Хотоос 23 хүний бүрэлдэхүүнтэй баг очиж ажилласан, эдгээр хүмүүс заалыг нь дүүргээд сууучихаар иргэд нь оролцох боломжгүй Соёлын төвийнх нь талыг дүүргэж байгаа

юм. Ингэж бид сүрийг бадруулсан ийм арга хэмжээ удаа дараа зохион байгууллаа, цаашид имй байдлаар явмааргүй байна. Арга хэлбэрээ ч, тавьж буй зорилтоо ч, нэр томьёололоо ч өөрчлөх хэрэгтэй.

Л.Долгормаа: Олон жил тайлан гаргалаа. Энэ тайлан хэнд хэрэгтэй юм бэ? Тайлангаа гаргасан компани бол яах юм, гаргаагүй бол яах юм. Байгалийн баялаг ард түмний мэдэлд учраас бид хянаж байх ёстой. Ийм учраас хууль гарах ёстой гэж бид үзэж байгаа. Гэтэл хууль батлуулах талаар төлөвлөгөөнд нэг ч өгүүлбэр байхгүй байна. Өнөөдөр би энэ тайланг бариад шүүхдэе гэвэл энэ хууль эрх зүйн баримт мөн үү? Тэгэхээр энэ тайлан юу юм? Би Өдрийн сонин дээр хууль гарах шаардлагатай гэсэн ярилцлага өгсөн. VIP сэтгүүл дээр ярилцлага өгсөн. Мөнгөгүй иргэний нийгмийн бид ингээд ажил хийгээд явж байна. Өнөөдөр төрийнхөн цалингаа аваад энд сууж байгаа, компаниуд бас цалингаа аваад энд сууж байгаа, иргэний нийгмийн бид ямар ч үнэ хөлсгүй энд суудаг, тэгээд байнга л нэг хуралд дууддаг, хоёр гурван цаг, заримдаа бүтэн өдөр ч оролцдог. Гэтэл олон сая төгрөгөөр сургалт, чуулган хийжээ, үүний үр дүн хаана байна вэ? Баярмаа бид 2 сая бүх аймгуудаар явсан, сургалт хийсэн. ОҮИТБС-ын тайлангийн талаар мэдэж байгаа хүн алга. Хөрөнгө оруулалт, хандив гэж юу юм гэдгийг тодорхойлохуйц тайлан байх хэрэгтэй. Дэлхийн банкнаас ямар их мөнгө зарцуулж байна вэ? Хүнд хэрэгтэй тайлан хиймээр байна шүү. Үр дүн 7 дээр ил тод, хариуцлагатай уул уурхайн уулзалт, өдөрлөг зохион байгуулна гэсэн байна. Мэргэжлийн холбоодод хариуцуулсан байна. Мэргэжлийн холбоо гэж хэнийг хэлж байна вэ? МУУҮА бол муу ч байсан сайн ч байсан компанийг л өмөөрдөг. Тиймээс энэ ажлыг Хариуцлагатай уул уурхайн санааачилга манай байгууллагад өгвөл ямар вэ? ийм саналтай байна. Бид үүнийг сайн зохион байгуулж чадна.

Б.Баярмаа: Жил болгон л орон нутагт сургалт, уулзалт, бүсийн чуулган хийнэ гээд яваад байгаа, үр дүнгүй л байгаа. Хан-уул дүүрэг дээр дэд зөвлөл байгуулж ажиллаа. Гэтэл тэд дэд зөвлөл нь ажлын хэсэг, ажлын албатай хэрхэн ажиллах талаар тодорхой ойлголтгүй сууж байна. Дэд зөвлөлүүд буцаад яаж Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлтэйгээ холбогдож, ямар эрх үүргийн ялгаатай байх юм? Зохицуулалт алга байна. Тэгэхээр эхлээд бид тоглоомын дүрмээ тодорхой болгомоор байна. Үндэсний зөвлөл нь юу хийх юм, Ажлын хэсэг нь, ажлын алба нь яаж ажиллах юм? Үнэхээр ажлаа муу хийсэн бол халагдах, солигдох, хариуцлага тооцох зүйл байх юм уу? Үүрд мөнх эндээ ингээд байж байх ёстой юмуу? Эхлээд стратеги төлөвлөгөөгөө боловсруулаад дараа нь дүрэм, журмаа тодорхой болгох хэрэгтэй. Хоёрдугаарт, агуулгын хувьд ажлаа төлөвлөж явмаар байна. Яагаад бид урьдчилсан баталгаажуулалтаар муу дүн авсан юм, үүнийгээ сайжруулах зүйлсийг ажлын төлөвлөгөөнд оруулах хэрэгтэй. Гэрээний ил тод байдал муу, лицензийн ил тод байдал муу гэсэн байхад өнөөдөр дарга нь лицензийн ил тод байдал сайн байгаа гээд загнаад гараад явж байна. Тэгээд иргэний нийгмийн бид хэд л үлддэг. За яахав татварын Энхтуяа, ашигт малтмалын Оюунтуяа байдаг. Гэхдээ энэ хүмүүс шийдвэр гаргах түвшний хүмүүс мөн юмуу биш юмуу? Тэгэхээр миний санал бол баталгаажуулалтын урьдчилсан дүнд мониторинг, үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах санал гаргаж байна.

Д.Эрдэнэчимэг: Үндэсний чуулганы үр дүнгээр 2020 он хүртэлх стратегид тусгах асуудлуудыг гаргаж ирсэн. Тэгэхээр эхлээд бид стратегиа боловсруулаад түүнд хүрэх ажлуудаа шат дараатай төлөвлөж гаргаж ирмээр байна. 2016 оны төлөвлөгөөг гаргахдаа баталгаажуулалтын урьдчилсан дүнтэй уялдуулан хиймээр байна. Үүнийг хийх ажлын хэсгийг байгуулах саналыг дэмжиж байна.

Хоёрдугаарт, орон нутгийг чадавхжуулах гэдэгтэй санал нэг байна. Орон нутгийн ИНБ-ууд чадавхитай байвал дэд зөвлөл идэвхтэй ажиллах боломжтой харагдсан.

Н.Энхбаяр: Орон нутгийн тухайд 4 аймаг, 6 сум гээд төлөвлөгөөнд орсон байсан. 21 аймагт ажиллаж чадахгүй. Үүндээр манай гишүүд санал нэгдэж байна уу?

Д.Эрдэнэчимэг: Нэгдэж байгаа. Бенефициар өмчлөгчийг хэн гэж үзэх талаар ажлын хэсэг зөвшилцөж нэг шийдвэрт хүрэх ёстой байгаа.

Н.Баярсайхан: Цолмонгоос асууя. Ажлын төлөвлөгөөг ондоо багтаж батлах ёстой байдаг уу? Үндэсний зөвлөлийг ахиад хэзээ хуралдуулах боломжтой вэ? Орон нутгийн түвшинд яаж хэрэгжиж байгаагаар л Монгол Улсын ОҮИТБС-ын хэрэгжилтийг үнэлнэ. Засгийн газрын 222-р тогтоолоор бүх сумдад дэд зөвлөл байгуулагдах ёстой болж байгаа. Ашигт малтмалын тухай хуулиар бүх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тайлан гаргах үүрэгтэй. Гэтэл бид өөрсдөө заавал биелүүлэх ёстой үүргийг нь 85%-д хүргэнэ, хэдэн аймаг суманд хүргэнэ гээд хумиад байгаа юм биш үү? Өнөөдрийг хүртэл дэд зөвлөлд чиглэсэн нэг ч үүрэг өгөөгүй байна. ТАН эвсэл л чиглэл өгөөд яваад байгаа. Хоёрдугаарт, Дэд зөвлөл хэрхэн зохион байгуулагдах,юу хийх, юу хийхгүй, Үз болон АА-тай хэрхэн эргэх холбоотой ажиллах талаар танилцуулга бэлдэж оруулах ёстой байсан. Гэтэл дэд зөвлөлийн санхүүжилтын асуудлыг судалж, шийдэл гаргах ажлаа хугацаанд нь хийч чадаагүй болохоор 2016 оны төлөвлөгөөнд орсонгүй, биднээс шалтгаалаад ажил хойшлогдоод байгааг ажлын алба анхаараарай. Гуравдугаарт, ажлын алба энэ чиг үүргийг хэрэгжүүлээд яваад байх нь зөв юмуу? Ажлын хэсэг нь юу хийх юм? Баахан төсөв тавьчихаад, Ажлын алба ажлаа дийлэхгүй бид хийх ёстой гэж ойлгоод л яваад байдаг. Ажлын хэсэг ажлыг албыг удирдамжаар хангах ёстой гэж ойлгоод байгаа. Бид ажлын албаны ачааллыг хөнгөлж өгөх ёстой. Ажлын алба орон нутагт баахан хүмүүс дагуулаад сүр бараатай яваад байна. Ажлын алба төслийн нэгж шиг ажиллаад байгааг хэлэх нь зүйтэй. ТАН эвсэл, МУУҮА зарим ажлуудыг нь гэрээгээр хийх боломжтой. Хурал даргалагчид хандаж дахин хэлэхэд ажлын хэсэг гаргаад энэ 2016 оны төлөвлөгөөний төслийг сайжруулах хэрэгтэй.

Ш.Цолмон: 1 сард багтаагаад 2016 оны төлөвлөгөөг батлах бололцоотой. Гэхдээ Үндэсний зөвлөлийн хурал 18-нд болох учраас яаравчилсан хэрэг. Хоёрдугаарт, хуралд оролцсон, орон нутагт томилолтоор явсан, илтгэл тавьсан гэх зэрэг тав зургаан үзүүлэлтээр та бүхний оролцоог үнэлж, урамшууллын тооцоо хийж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт танилцуулаад явж байна. Хэрэв батлагдвал та бүгдэд тэр урамшуулал олгогдоно. Ажлын алба бол Дэлхийн банк, Ерөнхий сайдын ажлын албаны дэргэдэх төслийн нэгж юм аа. Ийм учраас Дэлхийн банкны чиглэлээр, зөвлөмжөөр, журмын дагуу ажилладаг. Сангийн яамны Зээл тусламжийг хэрэгжүүлэх хууль байдаг. Энэ хуульд зааснаар ажлын алба нь төслийн нэгж юм.Нэгдүгээр сард, хоёрдугаар сард санхүүжилт саатаж болзошгүй байгаа.

Н.Баярсайхан: Үндэсний зөвлөлийн дараагийн хурлыг 2 сард зохион байгуулахаар бид ярих ёстой юм байна. Үндэсний зөвлөлийн хурлаар л бодлогын шийдвэрийг гаргаж хэлэлцмээр байна, гэтэл жилд нэгхэн удаа хуралдахаар бодлогын шийдэл гаргаж чадахгүй байна. Ажлын алба дан ганц Дэлхийн банкнаас хамаарахгүйгээр бусад газруудаас санхүүжих боломжуудыг судлах талаар Олон улсын нарийн бичгийн дарга нарын газартай ярих хэрэгтэй. Магадгүй анх гэрээ байгуулж байх үеэс одоогийн байгаа нөхцөл байдал өөрчлөгдсөн байж болох

талтай, иймээс бид Дэлхийн банктай байгуулсан гэрээний журамд өөрчлөлт оруулах саналаа гаргаад хүргүүлэхэд болохгүй юм байхгүй байх гэж бодож байна.

Н.Энхбаяр: Шийдвэрийн төсөлд Үндэсний зөвлөлд танилцуулах л гэж оруулсан байна л даа. Тэгэхээр одоо гишүүдийн хэлсэн саналыг тусгаад дахиж нэг хүргүүлэх үү? Төлөвлөгөөний 9.4 дээр стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах гээд оруулсан байна. 2016 оны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг тусад нь байгуулах гэсэн санал гарсан. Хэрэв байгуулна гэвэл Үндэсний зөвлөлийн хурал ирэх долоо хоногийн Баасан гарагт болно хугацааг нь шахуу тавьж өгөх нь. Мягмар гараг гэхэд ажлын хэсэг ажиллаад төслөө боловсруулж дуусгаад орой нь гишүүддээ хүргүүлээд, гишүүд саналаа Лхагва гараг орой гэхэд ирүүлэх гэвэл яаж байна?

Д.Эрдэнэчимэг: Цахимаар хүмүүс хэр санал өгч байна вэ?

Н.Энхбаяр: Энэ хэсэг дээр санал хураая. Мягмар гараг гэхэд 2016 оны төлөвлөгөөг дахин боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах нь зүйтэй гэсэн нь гараа өргөнө үү?

Н.Баярсайхан: Хуралдааны төгсгөл хэсэгт төрийнхөн болон компаны төлөөлөл явсан, ИНБ бараг дангаар үлдсэн байна. Санал хураахад ирц хүрэх юмуу?

Б.Дэлгэрмаа: 33 гишүүнээс 13 гишүүн байна.

Д.Цэрэнжав: Ажлын хэсэг ажиллаж амжихгүй. Үүний оронд ажлын алба гишүүдийн хэлсэн саналыг нэгтгээд оруулбал яасан юм бэ?

Н.Энхбаяр: За тэгвэл ажлын хэсэг байгуулах асуудал олонхийн дэмжлэгийг авч чадсангүй. Гишүүд санал их хэлсэн учраас өөрсдөө өөрсдийнхөө хэлсэн саналыг томъёолоод ажлын албанд ирүүлэх гэж шийдвэрлье.

Г.Чагнаадорж: Гишүүдийнхаа саналыг тусгаад, сайжруулаад ажлын алба нь эцэслээд явбал яасан юм.

Н.Баярсайхан: Ажлын хэсэг байгуулбал гол нь урьдчилсан баталгаажуулалтын дүн, үндэсний форумаас гарсан зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хараад 2016 онд тусгах эсэхийг ярилцах зорилготой байсан юм.

Ш.Цолмон: Урьдчилсан баталгаажуулалтын дүн гэсэн дээр бид ахиж нэг багана нэмээд ямар ажил хийж болох талаар оруулаад Даваа гарагт та бүгдэд явуулъя. Мягмар гарагт 2016 оны төлөвлөгөөний төслөө дахиж сайжруулаад явуулъя.

Д.Эрдэнэчимэг: Үндэсний зөвлөлөөр ажлын төлөвлөгөөгөө батлахгүй биз дээ? 1 сард дахиж хуралдаад батлах хэрэгтэй.

Ш.Цолмон: 1 сард дахиж хуралдуулахад хүндрэлтэй. Зарчмын хувьд батлах нь зүйтэй.

Н.Баярсайхан: 1 сард Үндэсний зөвлөлийн хуралдааныг зохион байгуулахад болохгүй зүйлгүй.

Н.Энхбаяр: Гол нь дэд зөвлөлүүдийн ажлуудаа тодорхой тусгах хэрэгтэй.

Н.Баярсайхан: Тодорхой байгаа, урьд ажлын хэсгийн хуралдаанд танилцуулж байсан мэдээлэл бий.

Н.Энхбаяр: Тэгвэл 18-нд танилцуулаад, батлуулах нь зүйтэй.

Д.Эрдэнэчимэг: Стратегийн баримт бичгийг эхлээд баталж байж, дараа нь төлөвлөгөө батлах хэрэгтэй.

Н.Энхбаяр: Стратегийн төлөвлөгөөг боловсруулах гэвэл 2016 оны төлөвлөгөөний 9.4-т орсон байгаа.

Н.Баярсайхан: Стратегийн баримт бичгийг батлуулахыг хүлээвэл 2016 оны төлөвлөгөө удах учир одоо батлуулах хэрэгтэй.

Н.Энхбаяр: За гишүүд саналаа хэлж дууслаа. Шийдвэрээ гаргая.

Шийдвэрлэсэн нь:

1. 2016 оны ажлын төлөвлөгөөний төсөл болон урьдчилсан баталгаажуулалтын дүнд Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг тусган нэгтгэж, Үндэсний зөвлөлд танилцуулахыг Ажлын албанд зөвшөөрөв гэсэн томъёололоор санал хураая. Зөвшөөрч байгаа нь гараа өгнө үү. (Н.Баярсайханаас бусад нь гар өргөв)

За ингээд өнөөдрийн хуралдаандаа идэвхтэй оролцсон та бүгдэд баярлалаа.

Хуралдаан 13:40 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУЯ-ны СТБГ-ын дарга Н.Энхбаяр

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг